

## Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 8 дугаар сарын байдлаар)

### I. Нийгмийн үзүүлэлт




#### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2015 оны 8-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1236 болж, 2014 оны мөн үеэс 193 хүнээр, өмнөх сарынхаас 277 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 50.49 хувь буюу 624 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхнээс 1210 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 612 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 39.54 хувь буюу 242 нь эмэгтэйчүүд байв. Зураг I.1


**Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 8 дугаар сарын эцсийн байдлаар**



Тайлант сард бүртгүүлсэн 331 ажилгүй иргэний 32.44 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 23.69 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 15.80 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 7.05 хувь нь шилжин суурьшсан; 3.77 хувь нь орон тооны цомхтголд орсон; 3.65 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 2.67 хувь нь байгууллага татан буугдсан; 2.31 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 2.31 хувь нь цэргээс халагдсан; 0.97 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй

болсон; 0.73 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 0.36 хувь нь тэтгэвэрт гарсан; 4.25 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ. Зураг I.2

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар**



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



#### I.2 Нийгмийн даатгал, халамж

##### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 8 сард НДШ-ийн орлого 9.0 тэрбум ₮ болж төлөвлөгөө 81.8 хувь болж, төлөвлөгөөг 13 сум 40.3-0.1 хувиар давуулан биелүүлж, харин Заамар, Баянчандмань, Эрдэнэ, Борнуур, Зуунмод, Жаргалант, Баянцогт, Батсүмбэр, Баян. Баянжаргалан, Угтаал, Архуст, Эрдэнэсант, Лүн 14 сум 55.3-1.0 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 133.6 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 28.0-15.9 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжид 23.9 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.0 хувийг өндөр настны, 10.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.2 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр, тэтгэмж 264970 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 32.9 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 21.8%; тэтгэмжийн даатгалын сангийн 97.4%; эрүүл мэндийн даатгалын сангийн 97.5%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 243.9%; ажилгүйдлийн даатгалын сангийн 142.9%-ийг тус бүр бүрдүүлжээ.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 8 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 50555 хүнд олгож, 7.1 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 4.8 хувь 2312 хүнээр өсч, зарцуулсан мөнгөний хэмжээ 4.8 хувь 332.2 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 114430 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.8 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 27.5 хувийг халамжийн тэтгэвэр; 9.6 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.9 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.4 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 3.8 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.9 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




### I.3 Эрүүл мэнд


2015 оны эхний 8 сард 9882 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.6 ор хоног ноглоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 8 сард 835 хүүхэд мэндэлсэн нь 2014 оны мөн үеэс 77 хүүхдээр буурлаа.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 8 н сард нялхсын эндэгдэл 8 гарч өмнөх оны мөн үеэс 3-аар өслөө.



5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй ба өмнөх оны мөн үед харьцуулвал 1 дахин буюу 1 хүүхдээр өссөн байна.

Зураг I.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



2014 оны эхний 5 сард нийт гарсан халдварт өвчнөөр 210 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 27.3 хувь буюу 79 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 2.9 дахин, заг хүйтэн 1.4 дахин, тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 24 байгаа бол: Зуунмод 66, Мөнгөнморьт 50, Сүмбэр 49, Дэлгэрхаан 26, Баян-Өнжүүл 25 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



#### I.4 Байгаль орчин

#### Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Төв аймгийн 2015 оны 8 сарын цаг агаарын байдлыг

олон жилийн дундажтай харьцуулсан тойм

- агаарын дундаж температур 18-21 градус дулаан буюу Өндөрширээт орчмоор дулаан, Мөнгөнморьтоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 29-38 градус буюу Бүрэн, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Лүн, Жаргалант, Угтаал, Заамар, Борнуур, Залуучууд орчмоор 32-38 градус хүрч халсан байхад нутгийн зүүн хойд хэсэг болох Мөнгөнморьт, Эрдэнэ, Зуунмод орчмоор 29-31 градус хүрч дулаарсан.

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 2-10 градус дулаан буюу Заамар, Баянцагаан орчмоор 9-10 градус, бусад нутгаар 2-8 градус, Эрдэнэ, Мөнгөнморьт орчмоор 2 градус дулаан ажиглагдсан байв.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 11,1-116,6 мм, нутгийн өмнөд хэсгээр бага үүнээс Дэлгэрхаанд 11,1 мм хамгийн бага нь, нутгийн хойд хэсэг болон зарим газраар арай ахиу, үүнээс хамгийн их нь Жаргалант, Залуучууд, Заамар, Батсүмбэр, Борнуурт 71,7-116,6 мм бороо оржээ.

-салхины их хурд нийт нутгаар 4-14 м/с, борооны өмнө түр зуур 18-23 м/с, Эрдэнэсантад 23 м/с хүрч ширүүслээ.

#### Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

-агаарын дундаж температур нь бүх нутгаар 1-3 градус орчмоор дулаан

-өдрийн хамгийн их температур нь бүх нутгаар 1-6 орчим градусаар дулаан ажиглагдсан

-шөнийн хамгийн бага температур нь бүх нутгаар 2-7 градус орчмоор дулаан ажиглагдсан

-сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд өмнөх оны 8-р сараас ихэнх

нутгаар ахиу Дэлгэрхаан, Баянжаргалан, Алтанбулаг орчмоор 1-5 мм орчмоор бага, Эрдэнэд ойролцоо бороо оров.

- салхины их хурд нийт нутгаар 4-14 м/с, борооны өмнө түр зуур 18-23 м/с, Эрдэнэсантад 23 м/с хүрч ширүүслээ.

### 2015 ОНЫ ЕСДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн агаарын температурын сарын дундаж нь нутгийн баруун хэсгээр 4-9 градус, бусад нутгаар 9-14 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим.

**Хүйтрэх үе:** Гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн өдөртөө 3-8 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, цочир хүйтэрнэ, өдөртөө 7-12 градус дулаан.

**Сэрүүсэх үе:** Нэгдүгээр арав хоногийн дунд үеэс сэрүүсч сүүлчээр нь уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 6-11 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 11-16 градус дулаан.

**Дулаарах үе:** Нэгдүгээр арав хоногийн эхэн болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус, өдөртөө 17-22 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 22-27 градус дулаан.

**Бусад хугацаанд:** Уулархаг уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 13-18 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус, өдөртөө 17-22 градус дулаан байх төлөвтэй.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Төв аймгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим. Дундаж нь Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр орчмоор 30-43 мм, бусад нутгаар 17-30 мм.

Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, дунд үеэр зарим газраар бороо орно. Дуу цахилгаантай. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар бороо, уулархаг нутгаар хур тунадас орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, дунд үеэр нутгийн хойд хэсгээр, сарын эцсээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, эцсээр зарим газраар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй.




### 1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 8 сард аймгийн хэмжээнд 639 гэмт хэрэг бүртгэгдэж 595 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 2.27 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.


Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 8 дугаар сараар




Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 8 дугаар сараар




Гарсан гэмт хэргийн 45.9 хувь нь хулгай, 25.0 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 14.9 хувь нь замын осол, 3.1 хувь нь танхай дээрэм, 1.3 хувь нь хүн амины хэрэг, 9.7 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Аргалант, Баяндэлгэр, Баян, Баянчандмань сумдад 18 дээш насны 10000 хүнд 605-130 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (106)-аас харьцангуй их гарлаа. Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 3 хэргээр буурлаа.



Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 8 дугаар сараар, Тэрбум ₮-гөөр



Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 3 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 32 эмэгтэй, 760 эрэгтэй нийт 792 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оны мөн үеэс 3 хүнээр буурлаа.




## Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 оны эхний 8 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 628 гүйцэтгэх хуудсанд нийт 2.57 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 22 гүйцэтгэх хуудсанд ногдох 549.3 сая ₮-ийн

материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 606 гүйцэтгэх хуудасны 2.02 тэрбум ₮-өөс 269 хуудасны 478.7 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 44.39 хувь, үнийн дүнгээр 23.65 хувь болж 2014 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 2.24 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 30.96 нэгжээр тус тус буурлаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, хувиар



## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2015 оны эхний 8 сард кассын орлого 253.0 тэрбум ₮, кассын зарлага 252.0 тэрбум ₮ болж, гүйлгээнд 3.3 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 2015 оны эхний 8 сарын байдлаар 121.4 тэрбум ₮ байгаа нь өмнөх оны эцсээс 3.3 тэрбум ₮-өөр өслөө.

2015 он гарсаар бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 84.8 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Иргэдийн хувийн хадгаламжинд 8 сарын 31-ний байдлаар 39.6 тэрбум ₮ байна.



Харилцах дансны үлдэгдэл 8 сарын 31-ны байдлаар 260702 иргэний 12.0 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.34-1.37 хувь, хугацаатай доод хүү 0.65-0.91 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.




## II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 оны эхний 8 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 7.0 тэрбум ₮, зарлага 39.0 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 101.43 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Бууны албан татвар, бусад албан татвар, төлбөр, хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, нохойн албан татвар, хүү торгуулийн орлого, төсөвт газрын өөрийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, төрийн өмч худалдсаны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2014 оны мөн үеэс 4.2 хувь буюу 307.5 сая ₮-өөр буурлаа. Аймгийн төсвийн орлогын 83.5 хувийг татварын, 14.5 хувийг татварын бус, 1.9 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2014 оны мөн үеэс татварын орлого 0.1 нэгжээр өсч, татварын

бус орлого 1.6 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 1.5 нэгжээр өслөө.



Аймгийн нийт 3 шатны орлого 9.5 тэрбум ₮ болж аймгийнх 5.9 тэрбум ₮ буюу 62.46 хувь, сумынх 1.1 тэрбум ₮ буюу 12.08 хувь, улсынх 2.4 тэрбум ₮ буюу 25.46 хувийг тус бүр бүрдүүлжээ.



Орон нутгийн төсвийн орлого 6.8 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 103.73 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.1 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 127.21 хувь биелж, Сэргэлэн, Зуунмод, Батсүмбэр, Борнуур, Баянчандмань, Эрдэнэ сумд 40.59-0.19 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 5.9 тэрбум ₮ болж 97.61 хувь биелж Баянжаргалан, Цээл, Угтаал, Баянцогт, Баян-Өнжүүл, Архуст, Баянцагаан, Өндөрширээт, Заамар, Эрдэнэ, Сэргэлэн, Борнуур, Эрдэнэсант, Жаргалант, Аргалант, Лүн, Мөнгөнморьт сумд төлөвлөгөө 39.87-1.04 хувиар тасалдууллаа.




### II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2015 оны 8 дугаар сард хэрэглээний үнийн индекс суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 59.87%, өмнөх оны мөн үеэс 8.98%, өмнөх сараас 0.96 хувиар тус тус өсөв.

Бараа, үйлчилгээний бүлэг	2015 оны 8 сард	
	пунктээр	хувиар
<b>Бүгд</b>	<b>0.96</b>	<b>100.00%</b>
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0.34	-35.70%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.13	13.90%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.06	6.41%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.02	2.35%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	1.58%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	1.09	113.25%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	-0.02	-1.79%

Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 8 дугаар сарын 0.96 хувийн өсөлтийн 1.09 нэгж (113.25%) нь боловсролын үйлчилгээний бүлгийн; 0.13 нэгж (13.90%) хувцас, бөс барааны бүлгийн; 0.06 нэгж (6.41%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн; 0.02 нэгж (2.35%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0.02 нэгж (1.58%) нь эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс тус тус шалтгаалжээ. Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.34 нэгжээр буурсан нь ерөнхий индексийн өсөлтийг хазаарлаж байна.

Зураг II.4



Хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 8.98% өссөн ба дэд бүлгээр үзвэл боловсролын үйлчилгээний бүлэг 32.5%; хувцас бөс бараа гутлын бүлэг 12.74%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 11.41%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 9.06%; тээврийн бүлэг 7.56%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 7.36%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 5.62%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 5.24%; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 4.15%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 2.99%; амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 1.76%-аар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 4.06%-аар буурав.



### II Ургац хураалт

9 сарын 1-ний байдлаар төмс 265.2 тонн, хүнсний ногоо 202.0 тонн хурааж авлаа. Урьд оны мөн үеэс төмс 4887.3 тонн, хүнсний ногоо 90.8 тонноор тус тус буурлаа.

9 сарын 1-ний байдлаар 6662.6 тонн өвс, 952.8 тонн гар тэжээл, 66411 га уринш бэлтгэв.



### II.5 Аж үйлдвэр

2015 оны эхний 8 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 24.87 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс 1.4 дахин буюу 14.69 тэрбум ₮-өөр өслөө. Оны үнээр нийт

бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Баянчандмань, Жаргалант, Зуунмод, Баянцогт, Баянцагаан сумд 44.21-1.67 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 94.50) хувийг эзлэв.


**Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 8 сарын байдлаар, мянган төгрөгөөр**

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг  
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2014	2015	2014	2015	Дунд зогсох % Percentage share to total		2015/2014%
	ҮИИ	ҮИИ	I-ҮИИ	I-ҮИИ	2014-I-ҮИИ	2015-I-ҮИИ	
Нийт дүн	2,257.33	2,247.64	10,172.92	24,870.75	100.0	100.0	244.5%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	1,214.85	1,099.15	5,143.22	20,402.74	50.56%	82.04	396.7%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	1,042.06	1,147.93	4,040.21	3,464.31	39.72	13.93	85.7%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	0.42	0.56	988.49	1,003.69	9.7	4.04	101.4%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, нийтлэх хэвлэх дуу бичлэг хийх үйл ажиллагаа, цахилгаан, дулаан уур үйлдвэрлэл өмнөх оноос 3.9 дахинаас-1.4 хувь буюу 15.25 тэрбумаас - 4.8 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.6 Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 8 сарын нийт үйлдвэрлэлтэд дулааны эрчим хүч 4.04, боловсруулах үйлдвэрлэл 13.93, ашигт

малтмал олборлолт 82.04 хувийг тус тус эзлэв.

**Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, хувиар**




## II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2015 оны эхний 8 сард 2.6 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2014 оны мөн үетэй харьцуулахад 19.98 хувь буюу 648.9 сая ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 59.47 хувь нь инженерийн барилга байгууламжид; 30.99 хувь нь орон сууцны бус барилгад; 9.54 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2014 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 23.58; орон сууцны барилгын ажил 10.40 пунктээр тус тус буурч инженерийн барилга байгууламжийн ажил 33.97 пунктээр өсөв. Зураг II.1

Барилгын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөгөөр



## II.7 Холбоо



Холбоо ашиглалтын орлого оны эхний 8 сард 142.2 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 64.0 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.43 хувь буюу 36.5 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 61.3 сая ₮ болсон ба нийт орлогын 77.13 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 22.86 хувийг албан бичгийн, 13.56 хувийг зорчигчдын, 63.58 хувийг бусад орлого бүрдүүлээ.

Зураг II.10

**Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр**

